



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын дарга  
болон дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг  
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Г.Банзрагч, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батзориг, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, С.Соёмбо-Эрдэнэ, П.Соёл-Эрдэнэ, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын үүсгэн байгуулагч Ш.Төмөрсүхийн гаргасан намын дарга болон дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Х.Батсүрэн, П.Соёл-Эрдэнэ нарын илтгэснээр хэлэлцээд

**ТОДОРХОЙЛОХ нь:**

Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын үүсгэн байгуулагч Ш.Төмөрсүхээс "... Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 6 дугаар Их хурлаар намын даргыг сонгож, намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсныг бүртгэж" өгнө үү гэжээ.

**ҮНДЭСЛЭХ нь:**

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын дарга болон дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 6 дугаар Их хурлаар баталсан намын дарга болон дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхтэй холбоотой асуудлаар Улсын дээд шүүхэд Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намыг төлөөлөн шүүхэд хандах, өргөдөл гаргах эрхийг Ш.Төмөрсүхэд олгосон байх тул намыг төлөөлөх эрхтэй этгээдээс хүсэлт гаргасан гэж үзэв.

**Нэг.Намын даргыг бүртгүүлэх өргөдлийн тухайд:**

Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т "Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ", 17 дугаар зүйлийн 17.6-д "Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага ... сонгоно" гэж, мөн Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын дүрмийн 4.4 дүгээр зүйлийн 4.4.2-т "Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын ээлжит бус их хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэг хувийн хүсэлт,

шаардлагаар хуралдуулна. ... их хурлын ирц 85 хувиас доошгүй тохиолдолд хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр гэж үзнэ” гэж тус тус заажээ.

Намын даргыг бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсарган ирүүлсэн материалыг судлан үзэхэд, тус намын Төлөөлөн удирдах зөвлөлийн 3 гишүүний шийдвэрээр намын ээлжит 6 дугаар Их хурлыг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр товлож, уг Их хуралд оролцох төлөөлөгчдийн тоог 80 гишүүнээр тогтоосноос Их хуралд 69 төлөөлөгч оролцож, 89 хувийн саналаар Ш.Төмөрсүхийг тус намын даргаар сонгожээ.

Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Намын дүрмийн 4.4 дүгээр зүйлийн 4.4.2 дахь хэсэгт нийцсэн байх тул Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын даргаар Ш.Төмөрсүхийг бүртгэх үндэслэлтэй байна.

**Хоёр.Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийн тухайд:**

Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.1-т “намын дүрэм, ... батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасан, 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 6 дугаар Их хурлаар намын дүрэмд өөрчлөлт оруулсан нь хуулийн зөрчилгүй, намын Их хурлыг товлон зарлах эрхтэй байгууллага болох Төлөөлөн удирдах зөвлөл нь хуралдаан зарласан, хэлэлцэх асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэсэн байх тул намын дүрэмд өөрчлөлт оруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Улсын дээд шүүх намыг дараах үндэслэлээр намын бүртгэлд бүртгэхээс татгалзана” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4.1-д “намын дүрэм, хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан” гэж заасан бөгөөд энэ тохиолдолд Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын ээлжит 6 дугаар Их хурлаар баталсан доорх намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн агуулга нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчөөгүй байна. Үүнд:

Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын ээлжит 6 дугаар Их хурлаас тус намын дүрмийн 4.1.1.1-д “Намын удирдах дээд байгууллага нь Төлөөллийн, Хяналтын, Гүйцэтгэх төв байгууллагатай байна”, 4.1.1.2-т “Намын бүх шатны хурлын ирцийг гишүүд, төлөөлөгчдийн 50-иас дээш хувьтай бол тухайн хурлыг хүчинтэйд тооцно”, 4.1.1.3-т “Намын удирдах дээд байгууллагын чөлөөт цагт бүрэн эрхийг хэрэгжүүлэх намын төлөөллийн төв байгууллагатай байх бөгөөд түүнийг жил тутам нэгээс доошгүй удаа хуралдуулна”, 4.1.1.4-т “Намын удирдах дээд байгууллагаас сонгогдсон Төлөөллийн, Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хорооны гишүүд нь дараагийн бүтэц сонгогдох хүртэл намын дүрмээр хүлээсэн эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлнэ”, 4.1.1.7-д “Намын удирдах дээд байгууллага нь дараах бүрэн эрхтэй”, 4.1.1.7.1-д “Намын дүрмийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах”, 4.1.1.7.2-т “Намын төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгож батламжлах”, 4.1.1.7.3-т “Хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох”, 4.1.1.7.4-т “Эдгээр байгууллагын тайланг дөрвөн жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хэлэлцэх”, 4.1.1.7.5-д “Намын нэрийг өөрчлөх, намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох, намын дүрэмд

заагдсан бусад асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх”, 4.1.2.1-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь Их хурлын төлөөлөгчдөөс сонгож баталгаажсан тэргүүлэгч долоогоос /7/ доошгүй тооны гишүүнтэй байна. УТБЗ-ийн гишүүдийн өргөтгөсөн бүрэлдэхүүнд нь намаас улс төрийн албан тушаалд сонгогдсон, томилогдсон гишүүд, намын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, нийслэл, аймаг сум, дүүргийн намын дарга, нарийн бичгийн дарга нар, намын гишүүд сонгуулийн журмаар сонгогдож мөн гишүүн бус иргэдийн төлөөлөл оролцуулж болно”, 4.1.2.2-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн гишүүн орон гарвал дотоод сонгуулийн хорооноос суудлын тоог хуваарилан нөхөн сонгох хуралдааныг жилд нэгээс доошгүй явуулж, аль нэг хүйсийн харьцааг улс төрийн намын Хуульд заасныг дагуу баримтална”, 4.1.2.3-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь сонгуулийн, цаг үеийн, улс орны хөгжлийн асуудлаар хуралдахдаа дүүргийн, орон нутгийг төлөөлөх төлөөлөгчдийн өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж болно”, 4.1.2.4-т “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын Ээлжит ба Ээлжит бус Их хурлыг төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал орон нутгийн төлөөлөгчдийн оролцоог хангаж хуралдуулна”, 4.1.2.5-д “Энэхүү Их хурлын бэлтгэл ажлыг урьдчилан хангаж, хугацааг нэг сарын өмнө төлөөлөгчдөд утас, хэвлэлээр мэдэгдэнэ”, 4.1.2.6-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь дараах асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 4.1.2.6.1-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн гишүүн нь орон гарсан тохиолдолд намын дотоод сонгууль явуулж авсан саналаар нь эрэмбэлэн нөхөн сонгогдсонд тооцож, өмнөх гишүүний үлдсэн бүрэн эрхийн хугацаанд ажиллах”, 4.1.2.6.2-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн Ээлжит, Ээлжит бус хурлаар Намын даргын бүрэн эрхийн хугацаа дууссан эсхүл орон гарсан тохиолдолд намын дүрэм, улс төрийн намын тухай хуулийн дагуу намын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгох;”, 4.1.2.6.3-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх”, 4.1.2.6.4-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь Гүйцэтгэх төв байгууллагыг гурваас доошгүй тооны гишүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгож, ажиллах журмыг нь батлах”, 4.1.2.6.5-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь намаас бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг тодруулах ажлыг зохиох, дотоод сонгуулийн хороотой байж болно”, 4.1.2.6.6-д “Хорооны бүрэлдэхүүнд тавих шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, дотоод сонгуулийн үйл ажиллагааны журам, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг батлах;”, 4.1.2.6.7-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь бие даан сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулан удирдах”, 4.1.2.6.8-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал болон бусад бүх шатны Ээлжит ба Ээлжит бус сонгуульд нэр дэвшигчийг хуульд заасны дагуу тодруулж батламжлах”, 4.1.2.6.9-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь намын бүх байгууллагад болон бусад сонгуульд нэр дэвшүүлэх, сонгох, томилоход гишүүдийн оролцооны ил тод, тэгш байдлыг хангаж, аль нэг хүйсийн төлөөллийг улс төрийн намын тухай хуульд заасныг баримтлах”, 4.1.6.10-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь дүрмийн шинэчилсэн найрууллага, нэмэлт өөрчлөлт, бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан бусад шийдвэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг намын дарга эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчид үүрэг болгох”, 4.1.2.6.11-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн гишүүн нь ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, дүрмийн хариуцлагад

тооцогдсоноос бусад тохиолдолд дахин өрсөлдөх эрхээр хангагдах”, 4.1.2.6.12-т “УТБЗ-ийн Ээлжит, Ээлжит бус хуралдааныг намын даргын эсхүл УТБЗ-ийн гишүүдийн гуравны хоёрын санал шаардлагаар УТБЗ 24 цагийн дотор зарлаж, хурлын шийдвэр нь намын дүрэм, хуульд заасны адил хүчинтэй үйлчилнэ”, 4.1.2.6.13-т “Энэхүү дүрмийн 4.1.2.6.2-т заасан сонгуулийг явуулахдаа эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хуучин даргыг өөрийн биеэр оролцуулах”, 4.1.2.6.14-т “УТБЗ-ийн хурлыг намын дарга удирдаж, түүнийг эзгүйд хурлыг тэргүүлэгчдийн дарга удирдана”, 4.1.2.7-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл”, 4.1.2.7.4-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь намын анхан, дунд шатны ажлын зорилтыг тодорхойлох тэдгээрийн санхүүгийн тайлан зэргийг хэлэлцэж, бүрэлдэхүүнийг сонгох, тоог тогтоож, аймаг, нийслэлийн намын хорооны даргыг сонгуулийн журмаар тодруулна”, 4.1.2.7.5-д “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын гишүүнийг нэгээс доошгүй жил татвараа бүрэн төлсөн тохиолдолд Улс Төрийн Бодлогын Зөвлөлд нэр дэвших эрх олгоно”, 4.1.2.7.6-д “УТБЗ-ийн гишүүн нь хуралдаанаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гурав ба түүнээс дээш оролцоогүй бол чөлөөлөгдсөнд тооцно”, 4.1.2.7.7-д “УТБЗ-ийн гишүүн нь татвараа төлөөгүй бол чөлөөлөгдсөнд тооцогдоно”, 4.1.2.7.8-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь хүнийг нөөцийг бүрдүүлж, албан тушаалд дэвшүүлнэ”, 4.1.2.7.32.19-д “УТБЗ-д сонгогдох ёс зүйн хэм хэмжээний журам”, 4.1.6-д “Гүйцэтгэх Зөвлөл нь дэргэдээ намын бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий бодлого судалгааны байгууллагыг ажиллуулна”, 4.1.7-д “Гүйцэтгэх Зөвлөл нь дараах асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 4.1.7.1-д “Гүйцэтгэх Зөвлөл нь гурваас доошгүй тооны гишүүнтэй байх”, 4.1.7.2-т “Гүйцэтгэх Зөвлөлийн бүрэлдэхүүнд бүх шатны нарийн бичгийн дарга нар орно. Хурлаа ЕНБД-аар зарлуулж, удирдуулах”, 4.1.7.3-т “Гүйцэтгэх зөвлөл нь хуралдаа шаардлагатай гэж үзвэл намын гишүүн, сонгуульт гишүүдээс урилгаар таслах эрхгүйгээр оролцуулах”, 4.1.7.4-т “Гүйцэтгэх Зөвлөл нь цаг үе, улс төрийн асуудлаар яаралтай шаардлага гарсан тохиолдолд хугацаа товлохгүй”, 4.1.7.5-д “Гүйцэтгэх Зөвлөл нь намын удирдлагын шийдвэрээр бүх шатны хурлын тов зарлах, оролцох гишүүдийн тоо ирцийг бүрдүүлэх, хурал зохион байгуулах газрыг тогтоох, хэвлэл мэдээллээр зарлах, хэлэлцэх асуудлыг боловсруулан санал оруулах, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах”, 4.1.7.6-д “Гүйцэтгэх Зөвлөл нь намыг төлөөлөх итгэмжлэлийг намын даргын зөвшөөрлөөр намын гишүүнд олгох”, 4.1.7.7-д “Гүйцэтгэх Зөвлөл нь бүх шатны хуралд оролцох гишүүдийн тоог тогтоохдоо танхим, цахимаар оролцох гишүүдийг тоог гаргах”, 4.1.7.8-д “Гүйцэтгэх Зөвлөл нь бүх шатны сонгуулийн журам боловсруулах санал Улс Төрийн Бодлогын Зөвлөлд оруулах”, 4.1.7.9-д “Гүйцэтгэх Зөвлөл нь намын анхан шатны байгууллагын журам боловсруулан УТБЗ-өөр батлуулах”, 4.1.7.10-т “Гүйцэтгэх Зөвлөл нь Намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахаар санал боловсруулан Улс Төрийн Бодлогын Зөвлөлд оруулах”, 4.1.7.11-д “Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүн бөгөөд ЕНБД нь санхүүгийн асуудал хариуцсан аудитын байгууллагын удирдах ажилтантай гэрээ хийх”, 4.1.7.12-т “Гүйцэтгэх Зөвлөл нь санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг сонгож, түүний ажиллах журмыг хуульд нийцүүлэн боловсруулах”, 4.1.7.13-т “Гүйцэтгэх Зөвлөл нь намын Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороотой холбоотой маргааныг шийдвэрлэх

журам боловсруулан Улс Төрийн Бодлогын Зөвлөлөөр батлуулах, дотооддоо шийдвэрлэх эрх хэмжээнээс хэтэрвэл хуулийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагад хандах;”, 4.1.7.14-т “Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүдийг өргөтгөсөн байдлаар намын гишүүдээс сонгох;”, 4.2.2.3-т “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хорооны гишүүнээр намын төлөөллийн байгууллага болон Гүйцэтгэх төв байгууллагын гишүүн, орон тооны ажилтан сонгохыг хориглоно”, 4.2.2.4-т “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хорооны үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно”, 4.2.2.5-д “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо нь маргааныг хянан шийдвэрлэхдээ үндэслэлээ тодорхой бичнэ”, 4.2.2.9-д “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хорооны даргыг гишүүд нь дундаас нэр дэвшүүлж хуулийн дагуу санал хураалтаар сонгоно”, 4.2.2.10-т “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо нь Намын сонгуульд болон улс төрийн албан тушаалд сонгогдох, томилогдох, сонгогдсон буюу томилогдсон намын гишүүнийг хууль, ёс зүйн хэм хэмжээ, дотоод журмыг өөрчилсөн талаар дүгнэлт гаргах”, 4.2.2.11-д “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо нь төлөөллийн төв байгууллага, Гүйцэтгэх төв байгууллага, Хяналтын ба намын бусад байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөллийн оролцоог улс төрийн намын тухай хуулийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргана”, 6.2-т “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын Удирдах дээд байгууллага, Төлөөллийн, Хяналтын, Гүйцэтгэх Зөвлөл, намын санхүүгийн ажилтан зэрэг бусад анхан шатны байгууллагууд нь дүрмээр олгогдсон эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, тогтоомж болон Улс төрийн намын тухай хууль, намын дүрмийн заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалтуудыг тус тус шинээр нэмж,

Намын дүрмийн 4.1-д “Намын удирдах дээд байгууллага.”, 4.1.1-д “Намын удирдах дээд байгууллага нь Эрхчөлөөг Хэрэгжүүлэгч Намын гишүүдийн, эсхүл тэдгээрийн төлөөлөгчдийн Ээлжит ба Ээлжит бус Их хурал мөн бөгөөд түүнийг дөрвөн жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хуралдуулна.”, 4.1.2-т “Намын төлөөлөгчдийн Их хурлын чөлөөт цагт ажиллах төлөөллийн төв байгууллага нь Улс Төрийн Бодлогын Зөвлөл /УТБЗ/ мөн”, 4.1.3-т “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн чөлөөт цагт намыг шуурхай удирдлагаар ханган ажиллах гүйцэтгэх төв байгууллага нь Гүйцэтгэх Зөвлөл /ГЗ/ мөн.”, 4.1.4-т “Намын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга /ЕНБ дарга/, намын дэд дарга нарыг намын Удирдлага гэж ойлгоно.”, 4.1.5-д “Намын дарга нь намыг төлөөлнө”, 4.2.2-т “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам нь дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, намын дүрмээр зохицуулах дотоод маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Хяналтын байгууллагатай байна.”, 4.3-т “Намын Хэрэг Эрхлэх Газар”, 4.3.3-т “ХЭГ нь Намын их хурал, УТБЗ, Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо /ХЗЕХ/, УИХ дахь ЭЧХН-н гишүүдийн бүлэг, зөвлөлд, намын удирдлагад үйлчилнэ”, 4.4-т “Намын сонгуулийн байгууллага”, 4.4.2-т “Сонгуулийн хороодын ажиллах журам, бүрэлдэхүүнийг намын даргын саналыг үндэслэн УТБЗ батална.”, 4.5.2-т “Санхүүжилтийн Хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг Гүйцэтгэх Зөвлөл санаачилж УТБЗ батална”, 5.1.1-д “ЭЧХН-н үзэл баримтлал, дүрэм, мөрийн хөтөлбөр, бодлого, шийдвэрийг дагаж мөрдөх, бүх шатны орон нутгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх, мөрийн хөтөлбөрийг батлах, түүнийг хэрэгжүүлэх үүрэг бүхий анхан, дунд шатны байгууллага байна”, 5.1.2-т “Орон нутгийн намын байгууллагуудын үйл

ажиллагаа зохион байгуулалтыг УТБЗ-с баталсан журмаар зохицуулна”, 5.1.5-д “Намын орон нутгийн байгууллагууд ЭЧХН-ын тэмдэг албан хуудсыг ашиглана”, 5.2.1-д “Нийслэлийн намын зөвлөл нь дотроо Нийслэлийн намын Улс Төрийн Бодлогын Зөвлөлтэй байна. Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд сонгуулийн зарчмаар байгуулагдана. Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоог үндэслэн дүүргийн намын зөвлөлд хуваарилна. Жил бүр нийт гишүүдийн 1/3 дээр эргэлтэд хамрагдах сонгууль явагдана”, 5.2.2-т “Нийслэлийн намын Улс Төрийн Бодлогын Зөвлөл гишүүнийг дүүргийн намын хорооны хурлаас намын нууц санал хураалтаар сонгоно”, 5.2.3-т “Нийслэлийн нам нь Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн хурлаас нууц санал хураалтаар сонгогдсон намын дарга Нийслэлийн намын ерөнхий менежер, Нарийн бичгийн дарга, ХЭГ-н дарга, гишүүнтэй байна”, 5.3.2-т “Яаралтай бага хурлыг ЭЧХН-ын төлөөллийн байгууллагын гуравны хоёр хувийн хүсэлт шаардлагаар хуралдуулна. Сонгогдох төлөөлөгчийг тухайн орон нутгийн намын байгууллага мандат олгож хуралд эрхээр баталгаажуулна.”, 5.4.1-д “ЭЧХН-ын салбар нь тус намын анхдагч байгууллага мөн болно. Салбар нь тухайн орон нутагт ЭЧХН-ын төв байгууллагын удирдлагаар түүний зааварчилгаагаар үйл ажиллагаагаа явуулна.”, 5.4.2-т “ЭЧХН-н Салбар байгуулахад есөөс доошгүй гишүүдтэй байна”, 5.4.3-т “ЭЧХН-н салбар нь намын уриа, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна”, 5.4.4-т “ЭЧХН-д гишүүн элсүүлж тэдний бүртгэлийг үнэн зөв гаргаж, тэдний үзэл бодол, улс эх орны төлөвлөгөөний талаарх асуудлыг дэвшүүлж байх үүрэгтэй.”, 5.4.5-д “ЭЧХН-н Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хорооны шийдвэрийг дагаж мөрдөх, тус улсын эдийн засаг, улс төрийн амьдралд идэвхтэй оролцоно”, 5.5.2-т “Намын Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь гишүүнийг тухайн зөвлөлийн анхан шатны намын гишүүдийн хүрээнд ИТХ-ын төлөөлөгчийн мандатын тоогоор нууц санал хураалтаар сонгоно. Жил бүр нийт гишүүдийн 1/3 дээр эргэлтэд хамрагдах сонгууль явагдана.”, 5.5.3-т “Тухайн шатны Намын Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн хурлаас 5-аас доошгүй гишүүнийг сонгоно. Эдгээр гишүүдээс намын дарга /ерөнхий менежер/, дэд дарга, ХЭГ-н дарга, нарийн бичгийн даргыг сонгоно. Энэ удирдах бүрэлдэхүүн нь орон тооны бус, орон тооны байна”, 5.5.4-т “Намын Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн хурлаар тухайн шатны ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг хэлэлцэж батална”, 5.5.5-д “Намын Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн хурлаас УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг тодруулан Намын төв байгууллагын УТБЗ-ийн хуралд оруулна”, 5.5.6-д “Дотоод сонгуулийн дэд хорооноос мандатын дагуу ГЗ-ийн болон УТБЗ-ийн гишүүн, Нийслэлийн намын Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн гишүүдийг нууц санал хураалтаар тодруулна”, 5.5.9-д “Аймаг дүүргийн намын хороо нь намын удирдлага болон тухайн шатнаас сонгогдсон 5-аас доошгүй гишүүдээс Намын Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн бүрдсэн байх ба шаардлагатай гэж үзсэн тохиолдолд намын удирдлагын саналаар зөвлөх эрхтэй гишүүдээр өргөтгөсөн хуралдаан явуулж болно”, 6.1.1-д “Намын бүх шатны хурал, Намын Улс Төрийн Бодлогын Зөвлөл /УТБЗ/, Гүйцэтгэх Зөвлөл /ГЗ/, Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо /ХЗЕХ/ нь дүрмээр олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэр гаргахдаа дараах заалтуудыг мөрдөнө”, 6.3.2-т “Нам тарах буюу өөр намтай нэгдэх тухай саналыг Их хуралд оруулах УТБЗ-ийн шийдвэр түүний бүх гишүүдийн дөрөвний гурваас дээш саналаар

гаргана”, 6.3.7-д “Төлөөлөгчдийн Их хурал нь дүрмийн 4.1.1.7 дахь заалтуудын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 6.4.3-т “Улс Төрийн Бодлогын Зөвлөл нь бүх шатны Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгоход чиглэл өгч болно”, 7.1-д “Зөвлөл нь УИХ сонгуулиар ЭЧХН-с нэр дэвшиж сонгогдсон болон элсэх хүсэлтэй албан журмаар гаргасан УИХ-ын гишүүдээс бүрдэнэ. Үйл ажиллагааны журмыг УТБЗ-ийн зөвшөөрснөөр тогтооно”, 7.2.1-д “Үйл ажиллагааныхаа талаар ЭЧХН-н удирдлага, УТБЗ, ГЗ-д мэдэгдэх;”, 9.1.3-т “ЭЧХН нь дүрэм мөрийн хөтөлбөртөө оруулсан нэмэлт өөрчлөлтийг хуулийн дагуу Улсын дээд шүүхэд бүртгүүлнэ”, 10.3-т “Намын боловсон хүчинг бэлтгэх, тэдний сургалтын санхүүгийн асуудлыг УТБЗ-ийн гишүүдийн саналыг үндэслэнэ.”, 10.4-т “Намын төв ба орон нутгийн удирдах албан тушаал, улсын ба орон нутгийн, дотоодын сонгуульт ажилд аль нэг хүйсийн хувьд улс төрийн намын тухай хуулийг баримтална” гэж тус тус өөрчлөн найруулж,

Намын дүрмийн 4.1.2.7.1-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн гишүүн чөлөөлөгдөхийг хүсвэл хүсэлтээ тухайн аймаг, сум, нийслэл дүүргийн хороонд албан журмаар гаргана”, 4.1.2.7.2-т “Хүсэлтээ дээрх байдлаар гаргаснаар УТБЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдсөнд тооцно”, 4.1.2.7.3-т “Хүсэлтийн хүлээн авсан намын салбар нь энэ талаар намын ЕНБ даргад 3 хоногийн дотор албан ёсоор мэдэгдэнэ”, 4.1.2.7.9-д “Намын салбарууд нь УТБЗ-ийн хуралд ажлаа тайлагнах, танилцуулахад ажлын арга барилын чиглэл, дэмжлэг үзүүлнэ” 4.1.2.7.12-т “Төрийн сонгуульд оролцох Намын мөрийн хөтөлбөрийн боловсруулахад анхан шатны байгууллага, горлигчидтой хамтарч ажиллана”, 4.1.2.7.13-т “Төрийн сонгуульд бусад улс төрийн хүчинтэй хамтарч оролцох талаар хэлэлцүүлэг явуулна”, 4.1.2.7.14-т “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч намаас бусад Улс төрийн хүчинтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээний бэлтгэл ажлыг ГЗ-өөр хангуулна”, 4.1.2.7.15-д “Хамтын ажиллагааны гэрээний үйлчлэл нь энэхүү дүрмээр зохицуулагдах харилцаанаас давж үйлчилж буй нь ХЗЕХ-гоор тогтоогдсон тохиолдолд уг гэрээг УТБЗ-ийн хуралдааны 2/3 саналаар шийдвэрлүүлнэ”, 4.1.2.7.16-д “УИХ-ын болон бусад сонгуулийн үр дүнд хамтарсан Засгийн Газар байгуулах шаардлага гарвал УТБЗ-ийн гишүүдээр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна”, 4.1.2.7.17-д “ЭЧХН-ын үзэл баримтлалыг дэмжиж, дүрмийг зөвшөөрсөн тохиолдолд намуудын нэгдэх хүсэлтийг албан ёсоор хүлээн авна”, 4.1.2.7.18-д “УТБЗ-ийн гишүүний нөхөн сонгуулийн дүнг хэлэлцэнэ”, 4.1.2.7.19-д “Намын ЕНБ даргаас УТБЗ-ийн гишүүдийг намын дүрмийн дагуу сонгосон, чөлөөлсөн тухай нэгтгэлийг сонсоно”, 4.1.2.7.20-д “ХЗЕХ-ын гишүүнийг нөхөн сонгох саналыг намын дээд байгууллагад санал болгоно”, 4.1.2.7.21-д “УТБЗ нь анхан, дунд шатны намын байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, шаардлага хүргүүлэх, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх ажиллагааг чиглүүлнэ”, 4.1.2.7.22-т “Намын санхүүгийн жилийн төсвийг боловсруулах ажлыг ГЗ-д чиглэл өгнө”, 4.1.2.7.23-т “ЭЧХН-ын хэвлэл, мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчийг батламжилна”, 4.1.2.7.24-т “УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг тодруулах үйл ажиллагааг зохион байгуулахад дотоод сонгуулийн хороог удирдлага арга барилаар хангана”, 4.1.2.7.25-д “Ерөнхийлөгчийн сонгуульд намаас нэр дэвшигчийн асуудлаар судалгаа, шинжилгээ хийж харьцуулна”, 4.1.2.7.26-д “Намаас Ерөнхий сайдад нэр дэвшигчийг дотооддоо удирдлагын түвшинд, шаардлагатай бол олон нийтээр хэлэлцүүлнэ”, 4.1.2.7.27-д “Ээлжит болон Ээлжит бус Их хурал хуралдуулах товыг тогтоох, хэлэлцэх асуудлыг чиглэлийг ГЗ-д өгнө”, 4.1.2.7.28-д “Намын төлөөлөгчдийн Их Хуралд намын үйл ажиллагааг идэвхжүүлэх санал

оруулж хэлэлцүүлнэ”, 4.1.2.7.29-д “Сонгуульд оролцсон үр дүнгээс шалтгаалж намын удирдлагад итгэл үзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэж УТБЗ-ийн нийт гишүүдийн 2/3 нь итгэл үзүүлээгүй тохиолдолд Ээлжит бус Их хурал зарлуулна”, 4.1.2.7.30-д “УТБЗ нь ГЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, сонгох асуудлыг дүрмийн дагуу зохион байгуулахыг ГЗ-д чиглэл өгнө”, 4.1.2.7.31-д “УТБЗ-ийн гишүүдийн олонхи нь шаардлагатай гэж үзвэл зарим бүрэн эрхээ ГЗ-д шилжүүлэх эсэхийг хэлэлцэнэ”, 4.1.2.7.32-т “УТБЗ нь дараах журмуудыг баталж мөрдүүлэх;”, 4.1.2.7.32.1-д “Ерөнхийлөгч, УИХ, Ерөнхий сайд бусад улс төрийн албан тушаалд нэр дэвшигчийг тодруулах журам боловсруулах;”, 4.1.2.7.32.3-т “Намын бүх шатны байгууллага, удирдах бүрэлдэхүүнийг сонгох дотоод сонгуулийн журам;”, 4.1.2.7.32.5-д “Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн гишүүдийг сонгох журам;”, 4.1.2.7.32.9-д “УТБЗ нь ГЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, сонгох журам;”, 4.1.2.7.32.16-д “УИХ дахь намын гишүүдийн бүлэг, зөвлөлийн ажиллах журам;”, 4.1.2.7.32.17-д “Гишүүний татварын журам;”, 4.1.2.7.32.18-д “УТБЗ-ийг шаардан хуралдуулах журам;”, 4.2.2.13-т “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо нь намын төлөөллийн байгууллагаас баталсан журмын дагуу ажиллана”, 4.2-т “Намын Хяналтын байгууллага”, 4.2.2.2-т “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хорооны гишүүдийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар намын удирдах дээд байгууллагаас сонгоно. Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хорооны гишүүн нь өөр албанд шилжвэл анхан шатны намын салбарын саналыг үндэслэн нөхөн сонгууль явуулна”, 4.2.2.1-д “Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй байна. Анхан, дунд шатанд хэсэгтэй байж болно”, 4.2.2.12-т “Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороо нь тус намын санхүүгийн асуудал, намын гишүүдийн сахилгын байдал, намын хөтөлбөр, дүрэм, намын ёс суртахууныг зөрчигчдөд хариуцлага тооцдог журам боловсруулж УТБЗ-д батлуулахаар санал оруулж болно”, 4.2.2.7-д “Хянан Зөвлөлдөх Ерөнхий хорооны гишүүн нь хүсвэл орон нутгийн намын хуралд ажиглагчаар оролцох дүрмийн талаар зөвлөх эрхтэй”, 4.2.2.8-д “Хянан Зөвлөлдөх Ерөнхий хороо нь намын удирдах дээд байгууллагын хуралд ажлаа тайлагнах, Улс Төрийн Бодлогын Зөвлөлийн хуралд зөвлөх, хянах эрхтэй оролцож болно”, 4.2.2.15-д “ХЗЕХ нь үйл ажиллагааныхаа журмыг дүрэмд нийцүүлэн боловсруулж УТБЗ-өөр батлуулна”, 4.2.2.16.3-т “Намын сонгуульд болон төрийн, улс төрийн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон намын гишүүн ёс зүйн хэм хэмжээ, дотоод журмыг зөрчсөн дүгнэлт гаргах;”, 4.2.2.16.7-д “Цаг хугацааны болон хүндэтгэн үзэх шалтгаанаар УТБЗ-ийн зарим эрх нь ГЗ-д шилжих нөхцөл үүссэнийг тогтоох;”, 4.1.9-д “Гүйцэтгэх зөвлөлийн онцгой эрх”, 4.1.9.1-д “ГЗ-д өргөтгөсөн байдлаар гишүүдийг аймаг, дүүргийн намын хорооны хурлын нууц санал хураалтаар дөрвөн жилээс илүүгүй бүрэн эрхтэйгээр сонгогдох;”, 4.1.9.2-т “Шаардлагатай гэж үзвэл намын даргын санаачилгаар ГЗ нь эгнээгээ зөвлөх эрхтэй гишүүдээр өргөтгөх;”, 4.1.9.3-т “Намын ЕНБ-ийн дарга ГЗ-ийн хурлыг даргалж, хэлэлцэх асуудлыг намын даргатай зөвшилцөж товыг тогтоох, дүрэмд өөрөөр заагаагүй бол өргөтгөсөн хуралдааныг 24 цагаас доошгүй хугацааны өмнө зарлах;”, 4.1.9.4-т “ГЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хурлын даргын саналаар шийдвэрлэх;”, 4.1.9.5-д “Намын даргын хоригийг ГЗ нь 7 хоногийн дотор хэлэлцэхээр хуралд оролцсон гишүүдийн 1/3-ийн дэмжлэг хүчингүй болгох;”, 4.1.8.7-д “УТБЗ-өөс эрх шилжсэн эсэх асуудлаар шийдвэр гаргавал биелүүлэх;”, 4.1.8.8-д “Бүх шатны нөхөн сонгуульд Намаас дахин нэр дэвшигчийг тодруулах ажлыг зохион байгуулахад оролцох;”, 4.1.8-д “Гүйцэтгэх Зөвлөл нь дараах үүрэгтэй;”, 4.1.8.1-д “Намын бодлого үйл ажиллагаатай холбогдсон улс орны нийгэм эдийн засаг, улс төрийн амьдралын бүхий л асуудлыг



авч хэлэлцэн санал дүгнэлт гаргах;”, 4.1.8.2-т “Төрийн бодлого болон цаг үеийн тулгамдсан асуудлаар хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалд ажиллаж байгаа гишүүдтэй ажил үүргийн хувьд хамтарч ажиллах;”, 4.1.8.3-т “Намын хүний нөөцийн хөгжил болон боловсон хүчний бодлогыг хөгжүүлэх;”, 4.1.8.4-т “Олон нийт, гишүүдийн дунд тодорхой асуудлаар хэлэлцүүлэг явуулах ажлыг зохион байгуулах;”, 4.1.8.5-д “Намын гадаад харилцааг эрхлэх, гадаад орны улс төрийн намтай харилцаа тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх;”, 4.1.8.7-д “УТБЗ-өөс эрх шилжсэн эсэх асуудлаар шийдвэр гаргавал биелүүлэх;”, 4.1.8.8-д “Бүх шатны нөхөн сонгуульд Намаас дахин нэр дэвшигчийг тодруулах ажлыг зохион байгуулахад оролцох”, 6.6.1-д “Энэхүү дүрмийн 4.1.4-т заасныг намын удирдлага гэнэ”, 6.6.5-д “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч намын салбарын хурал нь салбарын удирдлагын бүрэлдэхүүн, Их хурал нь намын Улс Төрийн Бодлогын Зөвлөл, Хянан Зөвлөлдөх Ерөнхий Хороог сонгоно.”, 6.7.2-т “Намын дарга УТБЗ-ийн хэлэлцэх асуудал товыг зарлан хуралдуулах.”, 6.7.3-т “Намын дарга ЕНБ даргыг томилуулах саналыг УТБЗ-ийн хуралд оруулах;”, 6.7.4-т “Намын үзэл баримтлал, эрхэм зорилго, мөрийн хөтөлбөр, их хурал, УТБЗ-ийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхдээ холбогдсон чиглэлийг намын байгууллага, гишүүдэд өгөх;”, 6.7.6-д “Намын дарга нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх саналыг ГЗ-тэй зөвшилцөн УТБЗ-ийн хуралдаанд оруулж хэлэлцэх;”, 6.8-д “Намын даргыг чөлөөлөх журам”, 6.8.1-д “Намын даргыг дараах үндэслэлээр УТБЗ-ийн хурлаар чөлөөлж, намын даргын сонгуулийг журмын дагуу явуулна”, 8.2.1-д “УТБЗ, ХЗЕХ-ны гишүүн ИХ-н болон УТБЗ-ийн хуралдаанд;” гэж тус тус шинэчлэн найруулсан,

Намын дүрмийн “3.6” гэснийг “3.7”, “3.5.10” гэснийг “4.1.2.7.10”, “3.5.11” гэснийг “4.1.2.7.11”, “3.5.34” гэснийг “4.1.2.7.32.2”, “6.5.35” гэснийг “4.1.2.7.32.4”, “6.5.37” гэснийг “4.1.2.7.32.6”, “6.5.38” гэснийг “4.1.2.7.32.7”, “6.5.39” гэснийг “4.1.2.7.32.8”, “6.5.41” гэснийг “4.1.2.7.32.10”, “6.5.42” гэснийг “4.1.2.7.32.11”, “6.5.43” гэснийг “4.1.2.7.32.12”, “6.5.44” гэснийг “4.1.2.7.32.13”, “6.5.45” гэснийг “4.1.2.7.32.14”, “6.5.46” гэснийг “4.1.2.7.32.15”, “6.6.5” гэснийг “4.2.2.14”, “6.6.8” гэснийг “4.2.2.6”, “6.7” гэснийг “4.2.2.16”, “6.7.1” гэснийг “4.2.2.16.1”, “6.7.2” гэснийг “4.2.2.16.2”, “6.7.4” гэснийг “4.2.2.16.4”, “6.7.5” гэснийг “4.2.2.16.5”, “6.7.6” гэснийг “4.2.2.16.6”, “6.7.8” гэснийг “4.2.2.16.8”, “6.7.9” гэснийг “4.2.2.16.9”, “6.7.10” гэснийг “4.2.2.16.10”, “6.8.11” гэснийг “4.2.2.16.11”, “6.7.12” гэснийг “4.2.2.16.12”, “6.9.6” гэснийг “4.1.8.6”, “6.9.9” гэснийг “4.1.8.9”, “6.10” гэснийг “6.5”, “6.10.1” гэснийг “6.5.1”, “6.7.2” гэснийг “6.5.2”, “6.11” гэснийг “6.6”, “6.11.2” гэснийг “6.6.2”, “6.11.3” гэснийг “6.6.3”, “6.11.4” гэснийг “6.6.4”, “6.11.6” гэснийг “6.6.6”, “6.11.7” гэснийг “6.6.7”, “6.11.8” гэснийг “6.6.8”, “6.11.9” гэснийг “6.6.9”, “6.11.2” гэснийг “6.7”, “6.11.2.1” гэснийг “6.7.1”, “6.11.2.5” гэснийг “6.7.5”, “6.11.2.7” гэснийг “6.7.7”, “6.11.2.8” гэснийг “6.7.8”, “6.12.2” гэснийг “6.8.2”, “6.12.3” гэснийг “6.8.3”, “6.12.4” гэснийг “6.8.4”, “6.13” гэснийг “6.9”, “6.13.1” гэснийг “6.9.1”, “6.13.2” гэснийг “6.9.2”, “6.13.3” гэснийг “6.9.3”, “6.13.4” гэснийг “6.9.4”, “8.1.2” гэснийг “8.2”, “8.1.2.2” гэснийг “8.2.2”, “8.1.3” гэснийг “8.3”, “8.1.3.1” гэснийг “8.3.1”, “8.1.3.2” гэснийг “8.3.2”, “8.1.3.3” гэснийг “8.3.3”, “8.1.3.4” гэснийг “8.3.4”, “8.1.3.5” гэснийг “8.3.5”, “8.1.3.6” гэснийг “8.3.6”, “8.1.3.7” гэснийг “8.3.7”, “8.1.38” гэснийг “8.3.8”, “8.1.3.9” гэснийг “8.3.9”, “8.1.4” гэснийг “8.4”, “8.1.4.1” гэснийг “8.4.1”, “8.1.4.2” гэснийг “8.4.2”, “8.1.4.2.1” гэснийг “8.4.2.1”, “8.1.4.2.2” гэснийг “8.4.2.2”, “8.1.4.2.3” гэснийг “8.4.2.3”, “8.1.4.2.4” гэснийг “8.4.2.4”, “8.1.4.2.5” гэснийг “8.4.2.5”, “8.1.4.2.6” гэснийг “8.4.2.6”, “8.1.4.2.7” гэснийг “8.4.2.7”, “8.1.4.2.8” гэснийг “8.4.2.8”, “8.1.4.2.9” гэснийг “8.4.2.9”, “8.1.4.2.10” гэснийг “8.4.2.10”, “8.1.4.2.11” гэснийг “8.4.2.11”,

“8.1.4.2.12” гэснийг “8.4.2.12”, “8.2” гэснийг “8.5”, “8.2.1” гэснийг “8.5.1”, “8.2.2” гэснийг “8.5.2”, “8.3” гэснийг “8.6”, “8.3.1” гэснийг “8.6.1”, “8.3.2” гэснийг “8.6.2”, “8.3.3” гэснийг “8.6.3”, “8.3.4” гэснийг “8.6.4”, “8.3” гэснийг “8.7”, “8.3.1” гэснийг “8.7.1”, “8.3.2” гэснийг “8.7.2”, “8.3.3” гэснийг “8.7.3”, “8.3.3” гэснийг “8.8”, “8.3.1” гэснийг “8.8.1”, “8.3.3.2” гэснийг “8.8.2”, “8.3.3.3” гэснийг “8.8.3”, “8.3.3.4” гэснийг “8.8.4”, “8.4” гэснийг “8.9”, “8.4.1” гэснийг “8.9.1” гэж тус тус өөрчилжээ.

Иймээс Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын даргаар Ш.Төмөрсүхийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1-д заасныг тус тус үндэслэн Эрхчөлөөг хэрэгжүүлэгч намын ээлжит 6 дугаар Их хурлын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01 шийдвэрээр батлагдсан намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН

П.СОЁЛ-ЭРДЭНЭ